Төрийн нарийн бичгийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн
57/24 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

| | |
|---|---|
| | Төрийн албаны тухай хууль хэрэгжсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан |
| √ | Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон |

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол |
| Дагаж мөрдөх огноо: | 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Салбарын түншлэл, өндөр технологи, инновацийн хөгжүүлэлт, гарааны компаний бодлого, зохицуулалт, хэрэгжилт хариуцсан шинжээч | Ахлах түшмэл, ТЗ-9 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарын түншлэлийн бодлого, төлөвлөлт болон өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөөний эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гарааны бизнесийг дэмжих, гарааны компанийг байгуулах, бүртгэх, хөгжүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт болон хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгжилт, зохицуулалтыг хангах, холбогдох арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
167 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

√ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол |
| Дагаж мөрдөх огноо: | 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Салбарын түншлэл, өндөр технологи, инновацийн хөгжүүлэлт, гарааны компаний бодлого, зохицуулалт, хэрэгжилт хариуцсан шинжээч | Ахлах түшмэл, ТЗ-9 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарын түншлэлийн бодлого, төлөвлөлт болон өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөөний эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гарааны бизнесийг дэмжих, гарааны компанийг байгуулах, бүртгэх, хөгжүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт болон хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгжилт, зохицуулалтыг хангах, холбогдох арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

| Албан тушаалын зорилт: |
|---|
| 1. Өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, бодлого, холбогдох дүрэм, журам, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, зохицуулалтыг боловсронгуй болгох, санал, шийдвэрийн төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, бодлогын шийдлийг тодорхойлж, хэрэгжилт, зохицуулалтыг хангах;<br>2. Салбарын түншлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх нэгдсэн бодлого чиглэлийг тодорхойлох, холбогдох арга хэмжээг түвшин бүрт зохион байгуулах, оролцогч талуудын түншлэл, үйл ажиллагааны уялдааг хангах талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулах, тэдгээртэй холбоотой бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг бодлогын нэгдсэн удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах;<br>3.Инновацийн тэргүүлэх чиглэлийн болон өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөөний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах, холбогдох дүрэм, журмын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалтыг хангах;<br>4.Инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал, шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрт шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэх, удирдлага зохицуулалтаар хангах;<br>5.Гарааны бизнесийг дэмжих, гарааны компанийг байгуулах, бүртгэх, хөгжүүлэх талаарх бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжилт, зохицуулалтыг хангах ажлыг зохион байгуулах;<br>6.Инновацийн үйл ажиллагаа, хөгжүүлэлт болон инновацийн төсөл бүртгэх, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилтийг хангах;<br>7.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. Бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх. |

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэхтэй холбоотой стратеги, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөтөлбөр, төлөвлөгөөний эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, шинэчлэх санал боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах; | Салбарын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт хангагдсан байна. | Г,Х |

МОНГОЛ УЛС ... ЗӨВШӨӨРӨВ ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Өндөр технологи, инноваци, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхтэй холбоотой стратеги, бодлого төлөвлөлт, хууль эрхзүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, салбарын хөгжлийн чиг хандлагыг тогтоох ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үр дүнг бодлого, шийдвэрт тусгах санал, төслийн хувилбар, шийдэл боловсруулах; | Салбарын хууль тогтоомж, бодлого, эрх зүйн орчны төлөв байдал, цаашдын зураглал, бодлого төлөвлөлтөд дүн шинжилгээ, судалгаа хийгдсэн байдал, түүнийг салбарын бодлого, шийдвэр, саналд тусгасан байна. | Г,Х |
| | 3.Салбар/инноваци, өндөр технологи, шинжлэх ухаан, технологийн салбар/-ыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, холбогдох дүрэм журам, эрх зүйн зохицуулалтын төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх. | Салбарын түншлэл, инновацийг хөгжүүлэх асуудалтай холбогдох хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | ГХ |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Шинжлэх ухаан – Аж үйлдвэрийн уялдаа холбоог хөгжүүлэх, хамтран ажиллах эрх зүйн орчныг сайжруулах, хэрэгжүүлэх; | Эрх зүйн зохицуулалт хангагдсан байна. | Г,Х, Т |
| | 2.Шинжлэх ухаан, технологийн салбар, инновацийн үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрхзүйн боломж нөхцөл, зохицуулалтын талаар санал боловсруулж, хэрэгжилтийг хангах; | Эрх зүйн зохицуулалт хангагдсан байна. | Г,Х, Т |
| | 3.Инновацийн төсөл бүртгэх холбогдох дүрэм, журмыг боловсруулж, батлуулах, хэрэгжилт хангах; | Эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилт хангагдсан байна. | Г,Х |
| | 4.Салбарын түншлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх нэгдсэн бодлого чиглэлийг тодорхойлох, холбогдох арга хэмжээг түвшин бүрд зохион байгуулах; | Салбарын түншлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх нэгдсэн бодлого чиглэл тодорхойлогдсон байна. | Г, Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 5.Шинжлэх ухаан, технологийн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх; | Эрх зүйн зохицуулалт хангагдсан байна. | Г,Х, Т |
| | 6.Инновацийн үйл ажиллагаанд бүтээмжийн өсөлтийн механизмыг нэвтрүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тогтмол мэдээллийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, зохицуулалтыг хангах. | Бүтээмжид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээний тоо, чанарын үзүүлэлт, гүйцэтгэл, үр дүн | Г,Х,Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх асуудлаарх бодлого, төлөвлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага болон холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах, | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн хангагдсан байдал | Г,Х, Т |
| | 2.Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. | Инновацийн үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагаа сайжирсан байна. | Г,Х,Т |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлахтай холбоотой бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмыг боловсруулж, батлуулах, хэрэгжилт хангах; | Судалгааны ажлууд хийгдэж, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байдал | Г,Х,Т |
| | 2.Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагатай хамтран хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх; | Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, чанар хүртээмж нэмэгдсэн байдал | Г,Х,Т |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Инновацийн үйл ажиллагаанд бүтээмжийн өсөлтийн механизмыг нэвтрүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах; | Бүтээмжид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээний тоо, чанарын үзүүлэлт, гүйцэтгэл, үр дүн | Г,Х,Т |
| | 4. Инновацийн болон салбар/шинжлэх ухаан, инноваци, технологи/-ын оюуны өмчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн санал боловсруулах; | Салбар/өндөр технологи, инноваци, оюуны өмч/-ын санхүүжилтийн тогтолцоо бүрдсэн байдал | Г,Х |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Гарааны бизнесийг дэмжих, гарааны компани байгуулах эрхзүйн орчин, бодлого, чиглэл, төлөвлөгөө, шийдвэрийн төсөл боловсруулах, холбогдох дүрэм журам, хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх; | Эрх зүйн зохицуулалт хангагдсан байдал Гарааны компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ, өсөлт | Г, Т, Х |
| | 2.Гарааны компани бүртгэх, тэдгээрт татварын болоод бусад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах. | Төлөвлөгөө батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн гарсан байна. | Г, Т, Х |
| 6 дугаар зорилтын хүрээнд | 1.Өндөр технологи, инновацийн үйл ажиллагаа, хөгжүүлэлттэй холбоотой болон инновацийн төсөл бүртгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмыг боловсруулж, батлуулах, хэрэгжилт хангах; | Эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилт хангагдсан байдал | Г,Х |
| | 2.Инновацийн төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, инновацийн бүтээгдэхүүнийг худалдан авалтаар дэмжих ажлыг төлөвлөн зохион байгуулах; | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байдал | Г,Х,Т |
| | 3.Дээрх чиг үүргийн хүрээнд хамаарах арга хэмжээ болон эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын инновацид чиглэсэн үр дүнгийн талаарх мэдээллийн сан үүсгэх, санд тогтмол оруулах, шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар санал боловсруулах. | Салбар/өндөр технологи, инноваци, оюуны өмч/-ын санхүүжилтийн тогтолцоо бүрдсэн байдал Инновацийн төслийн мэдээллийн сан бүрдсэн байдал | Г,Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

<table>
<tr><td rowspan="4">7 дугаар зорилтын хүрээнд</td><td>1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;</td><td>Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, чанар, үр дүн</td><td>Г, Х</td></tr>
<tr><td>2.Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;</td><td>Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв, цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байдал</td><td>Г</td></tr>
<tr><td>3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;</td><td>“Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байдал</td><td>Г</td></tr>
<tr><td>4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх.</td><td>Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжилт хангагдсан байдал</td><td>Т, Г, Х</td></tr>
<tr><td colspan="4">III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</td></tr>
<tr><td>Боловсрол</td><td colspan="3">- Бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй</td></tr>
<tr><td>Мэргэжил</td><td colspan="3">- Байгалийн шинжлэх ухаан /053/, менежмент ба удирдахуй /041301-041303/, математик, статистик /054/, инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /071/, нано шинжлэх ухаан, инженерчлэл /078801/.</td></tr>
<tr><td>Мэргэшил</td><td colspan="3">- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх</td></tr>
<tr><td>Туршлага</td><td colspan="3">- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх</td></tr>
<tr><td rowspan="2">Ур чадвар</td><td>Дүн шинжилгээ хийх</td><td colspan="2">- өндөр технологи, инноваци, оюуны өмчийн бодлогын зохицуулалт, хэрэгжилтийн асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах;<br>- хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;<br>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;<br>- баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх;<br>- мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах;<br>- бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах;<br>- бусад.</td></tr>
<tr><td>Асуудал шийдвэрлэх</td><td colspan="2">- язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | - эрхлэх асуудалд хамаарах ажил үүргийг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн чанартай гүйцэтгэх;<br>- бодит баримт нотолгоонд тулгуурлан асуудлын шийдлийн хувилбарыг боловсруулж түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлон нэгжийн удирдлагад танилцуулах;<br>- салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар хууль тогтоомж болон нийтийн эрх ашигт нийцсэн, оновчтой, үр дүнтэй санал боловсруулах;<br>- эрхлэх асуудлын хүрээнд аливаа асуудлыг хууль болон төрийн албаны зарчимд нийцүүлэн ашиг сонирхлыг зөрчлөөс ангид шийдвэрлэх;<br>- шийдлийн хувилбар, санал, мэргэшлийн зөвлөмж, зөвлөгөөний үнэн зөв байдал, үр дагаврыг хариуцах;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах;<br>- хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;<br>- бусад. |
| | Бусад | - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах;<br>- харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах;<br>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;<br>- албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах;<br>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;<br>- төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах. |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:<br>Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга | |
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>- байхгүй | Бусад харилцах субъект:<br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага. |

| V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ<br>……………… /Б.ГАНТУЛГА/<br>(Гарын үсэг)<br>2022 оны 04 дугаар сарын 04-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 22 0330<br>Дугаар: 167 |
| Албан тушаалын тодорхойлолт баталсан: | |
| Байгууллагын нэр:<br>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ<br>Шийдвэрийн огноо: 2022.04.04<br>Дугаар: А/24<br>(тамга/ тэмдэг)<br>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА<br>……………… (Гарын үсэг) /Л.ЦЭДЭВСҮРЭН/ (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2022 оны 04 дугаар сарын 04-ны өдөр | |

МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ